

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бигэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2024/149/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 70483413 Цахим хаяг: Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn "Цэгц төв богд аудит" ХХК-ийн Ахлах аудитор Р.Цанжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	302,680.6	161,993.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	763,173.8	894,890.8
	Нийт хөрөнгийн дүн	1,065,854.4	1,056,884.0
	Нийт өр төлбөрийн дүн	-	1,929.4
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,065,854.4	1,054,954.6
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,065,854.4	1,056,884.0
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,602,595.7	755,486.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	731,958.1	762,846.8
	Үйл ажиллагааны үр дүн	870,637.5	(7,360.4)
	Үйл ажиллагааны бус үр дүн	12.2	3,539.3
	Үйл ажиллагааны нийт үр дүн	870,625.2	(10,899.8)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	200.59061	1,065.854.4
	Тайлант оны үр дүн	(870,625.2)	(10,788.8)
	Эцсийн үлдэгдэл	1.065.85464	1,054,954.6
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	751,359.8	552,720.5
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	626,131.5	675,226.8
	Үйл ажиллагааны ЦМГ	180,091.5	(122,506.3)
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(36,097.9)	(9,440.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	143,993.6	(131,946.3)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	143,993.6
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	143,993.6	12,047.3
Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		665,771.8
	Урсгал зардал		665,771.8
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		533,825.5
	Эрүүл мэндийн даатгалын сангаас		533,825.5
	Туслах үйл ажиллагааны орлогоос		
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл		12,047.3
Төсвийн гүйцэтгэлийн тайлан ОН			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		13,867.4
	Урсгал зардал		13,867.4
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		13,867.4
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		13,867.4

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 14.4 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитаар залруулсан. Үүнд:

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой** : Тайлан оны элэгдлийн зардлыг 3.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- Санхүүгийн байдлын тайланд 10.9 сая төгрөгийн тайлант оны үр дүнг тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;"-ыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 2.2 сая төгрөгийн 4 зөрчил илэрсэнээс нэмэгдэл цалин нөхөн олгох 1 төлбөрийн акт, зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1.Нийгмийн эрүүл мэндийн ажилтанд орон нутгийн нэмэгдэл 0.9 сая төгрөг олгоогүй нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 2-т " Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэмэгдлийг дараахь албан тушаал эрхэлж байгаа эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр олгоно. Сум (сум дунд), тосгоны эрүүл мэндийн төвийн Сувилахуйн/эх барихуйн мэргэжилтэн, Эмчилгээ оношилгооны тоног төхөөрөмжийн техникч, лаборант, Эрүүл мэндийн бусад мэргэжилтэн, Эм зүйн мэргэжилтэн, Түргэн тусламжийн жолооч "-д 15 хувиар олгоно (Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон бөгөөд үүнийг 2023-1-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу олгосон нэмэгдлийг нөхөн олгох төлбөрийн акт хүргүүлсэн.

5.2 Албан шаардлага

1. Эм боох материалын үлдэгдэлд хугацаа дууссан 65 нэр төрлийн 6067 ширхэг 11.8 сая төгрөгийн эм бэлдмэл байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-т "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх"-тэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Дотоодын хяналтыг сайжруулан хугацаа дууссан эмийг холбогдох журмын дагуу шийдвэрлэж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2.Тендерт шалгараагүй 1 аж ахуйн нэгж байгууллагаас 1.3 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерт шалгарсан этгээдээс худалдан авалт хийж байх албан шаардлага хүргүүлсэн.

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

3. Төрийн аудитын байгууллагаас тогтоосон 2023 оны 01/90 дугаартай төлбөрийн акт, 01/117-07/117 дугаартай албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитын шийдвэр хэрэгжүүлээгүй Эрүүл мэндийн даргад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
							Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бигэр сумын Эрүүл мэндийн төв	2	14.4	-	-	2	14.4	2	14.4	-	-	-	-	
Дүн	2	14.4	14.4	-	-	2	14.4	2	14.4	-	14.4	-	2

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бигэр сумын Эрүүл мэндийн төв	3	2.2	1	0.8	2	1.4						
Дүн	3	2.2	1	0.8	2	1.4			-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн	Байгууллага, нэгжийн тоо	Санал дүгнэлтийн хэлбэр
---	---------	--------------------------	-------------------------

	захирагчийн ангилал	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалт ай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1	-	-	-
	НИЙТ	1	1	-	-	1	-	-	-